



# ОНЦГОЙ МЭДЭЭ

2023 оны аравдугаар сар

№ 19 (196)

14 хоног тутмын хэвлэл

II НҮҮРТ

V НҮҮРТ

XII НҮҮРТ



**"АНГИ" БОЛДОО**



**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗАСАГЛАЛ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ**



**В.БАТСАЙХАН: ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГАД АШИГЛАЖ БАЙСАН БҮХ ТӨРЛИЙН АВТОМАШИНЫ ЗАГВАР НАДАД БИЙ**

## МОНГОЛ УЛС ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАН АЖИЛЛАЖ БҮЙ 94 ДЭХ ОРОН



**"ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА"**

Япон улсын Хёго хотноо 2005 онд зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах II бага хурлаар Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийг байгуулах саналыг дэвшүүлсэн. Улмаар 2015 онд Сендай хотод болсон III бага хурлын үеэр энэхүү зөвлөлийг баталгаажуулах ажил олон улсын түвшинд хийгдэж эхэлсэн. Энэ хүрээнд НҮБ-д бүртгэлтэй 187 улсаас Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийг байгуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй 94 дэх улс болсон юм.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл; аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд орон нутгийн зөвлөлийг байгуулж, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Дээрх хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2018 оны 63 дугаар тогтоолоор Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний

зөвлөлийн ажиллах журам болон бүрэлдэхүүнийг анхлан батлуулав. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 2020 оны нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан Засгийн газрын 2020 оны арваннэгдүгээр сарын 25-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор энэхүү зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчилж батлуулсан. Мөн энэ оны Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 38 дугаар тогтоолоор үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Ийнхүү шинэчлэн баталснаар үндэсний болон аймаг, орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл байгуулах эрх зүйн орчин бүрдэж, өнөөдрийн байдлаар үндэсний хэмжээнд нэг зөвлөл, хоёр дэд зөвлөл аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд 31 орон нутгийн зөвлөл үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Үргэлжлэл нь III нүүрт**

## ДУГААР ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Эрхэм хүндэт уншигч Та бүгдийн амрыг эрэн мэндчилье.

"Онцгой мэдээ" сонины энэ удаагийн дугаарыг Эрсдэлийн удирдлагын газраас эрхлэн гаргаж байна. Тиймээс бид та бүхэндээ гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл, авч хэрэгжүүлж буй ажил, гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн Зөвлөлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэхийг зорилоо. Мөн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар танилцуулга бэлтгэв.

Хүн төрөлхтөн олон зуун жилийн турш аливаа эрсдэл дор амьдарч ирсэн хэдий ч эрсдэлийн шинжлэх ухаан саяхнаас үүсэж, хөгжлийн шинэ шатандаа явж байна. Монгол Улс үндэсний болон 21 аймаг, нийслэл, есөн дүүрэгт тус зөвлөлийг байгуулж ажиллаж эхэлснээс хойш 3-5 жилийн хугацаа өнгөрчээ. Мөн 2023 онд хоёр дэд зөвлөлийг шинээр болон шинэчлэн байгуулсан. Энэ хугацаанд Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг чадавхжуулахад онцгойлон анхаарч Азийн хөгжлийн банкны санхүүжилт болон бусад олон улсын байгууллагуудтай хамтран жил бүр сургалт зохион байгуулсаар ирлээ. Шинэ тутам хөгжиж чадавхжиж байгаа зөвлөлийн гишүүдэд зөвхөн дотоод гэлтгүй гадаад улс орнуудад ч сургаж чадавхжуулахыг эрмэлздэг. Иймээс гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын хурал, сургалт семинарт аль болох оролцуулахыг хичээж зорьж ажилладаг дуулгая.

Эдгээр болон бусад мэдээллийг бэлтгэхийн сацуу Эрсдэлийн удирдлагын газар Монгол Улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог оновчтой болгох, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох үндсэн чиг үүргийн хүрээнд хийж буй ажлаа танилцуулахыг мөн зорилоо.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад шинжлэх ухаан, инновацын ололтыг нэвтрүүлж, шинжлэх ухаанд суурилсан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хөгжүүлэхийн төлөө хамтдаа зүтгэцгээе!

Хүндэтгэсэн,  
**ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА Д.БААСАНСҮРЭН**

### СТАТИСТИК МЭДЭЭ



## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН "ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМ" БАТЛАГДЛАА

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны аравдугаар сарын 20-ны өдрийн А/338 дугаар тушаалаар Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, батлагдлаа. Тус дүрмийг дагалдан хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааны хяналтын хуудас, шалгалтын дүнгийн хүснэгт, зааварчилгааны бүртгэлийн хуудас зэрэг холбогдох акт, эмийн сангийн жагсаалт, мэдэгдэх хуудас батлагдан гарч байгаа юм.

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-тэй дараах QR кодыг уншуулан танилцана уу.



## АЛБА ХААГЧИД СУВИЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГУУЛАГЧИЙН ХУВИАР АВНА

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны зургаадугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоол өнгөрсөн наймдугаар сараас хэрэгжиж эхэлсэн. Үүнтэй холбогдуулан алба хаагч болон иргэдэд сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх журамд өөрчлөлт оржээ. 13.1 дэх заалтад иргэн даатгуулагчдад сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг ЭМД-ын сангаас жилд нэг удаа иргэнээс 175 мянган төгрөг, ЭМД-ын сангаас 250 мянган төгрөгөөр санхүүжүүлнэ гэж заасан. Тиймээс алба хаагчид эрүүл мэндийн даатгуулагчийн хувиар Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Жаргалант сэргээн засах төв, 113 дугаар ангийн тусламж, үйлчилгээ авах боломжтой боллоо гэж Жаргалант сэргээн засах төв 113 дугаар ангиас мэдээллээ.







# АНГЛИ” БОЛДОО

**Бэлтгэл хурандаа Ш.Болдбаатар. Гүүр туннелийн барилгын инженер, иргэний хамгаалалтын штабын офицер мэргэжилтэй. Аюулгүй байдлын ухааны боловсролын доктор.**

**Түүний намтрыг харвал ажлын гараагаа ерөнхий инженерээс эхэлсэн байх. Ерөнхий инженерээс “тушаал буурч” байлдагч, байлдагчаас салаа, салбарын захирагч, ахлах, зөвлөх, дарга захирал гээд явж. Орос, англи, франц хэлтэй. Хэнтий аймагт томилогдон ажиллаж байхдаа аймгийн захиргааныханд англи хэлийг үнэгүй, сайн дураараа заадаг байжээ. Тэр үеэс “англи” Болдоо хэмээх бас нэгэн “цол” нэмсэн. Өнөө цагт тун хэрэгцээтэй мэргэжилтэй, хэд хэдэн гадаад хэлтэй түүнийг тэтгэвэртээ суусан гэж сонсоод “эрдэм, мэдлэгийг нь ашигладаггүй юм байх даа” гэх харамсал төрөөд байв. Харин тэр зүгээр суугаагүй. Орчуулга хийж, Дэлхийн банкны төслийн зөвлөхөөр ажиллахын хажуугаар ач, эзэгээ сургуульд зөөх том алба хашиж яваа.**

**Мөн тэрээр “Онцгой мэдээ” сониноор дамжуулан “Намайг дэмжиж, тусалж явсан үе үеийн Иргэний хамгаалалтын болон Онцгой байдлын албаны удирдлага, хамт ажиллаж байсан нөхөд, 122 дугаар анги, Хэнтий аймгийн Ардын депутатын хурлын /хуучин нэрээр/ Гүйцэтгэх захиргааны хамт олонд талархаж явдгаа илэрхийлснийг хүлээн авна уу.**

### -Ажиллаж байсан албан газраа гаднаас нь харж явахад ямар сэтгэгдэл төрж байна вэ?

-Бидний байгуулсан Онцгой байдлын албыг сайхан авч явж байна. Олон залуу өргөсөн тангарагтаа үнэнчээр, эр зориг гарган эх орныхоо төлөө ажиллаж байгааг хараад бахархаж явдаг. Цалин, хангалт нэмэгдэж алба хаагчид нь эрч хүчтэй байгааг харахад таатай байна.

### -Та гүүр туннелийн барилгын инженер мэргэжилтэй юм билээ. Яагаад цэргийн хүн болчихсон юм бэ?

-Хувь тавилан л юм даа. Би, ЗХУ-ын Минск хотын Политехникийн дээд сургуулийг гүүр туннелийн барилгын инженер мэргэжлээр 1975-1981 онд суралцан төгсөж ирсэн. Ирээд Улаанбаатар хотын Зам гүүрийн конторт мастер, ерөнхий инженерээр ажиллаж Сэлэнгэ аймгийн Шаамарт гүүр барьж байлаа.

Тэр үедээ цэрэгт татагдсан. Цэрэгт татагдахад инженерийн ангид хуваарилна, Хялганатын фронтонон гүүрт техникийн инженерээр явуулна гэж байв. Тухайн үед Батлан хамгаалах яамны, инженерийн хэлтсийн даргаар ажиллаж байсан Г.Өлзийбат хурандаа намайг зам гүүрийн 015 дугаар ангид оруулна гэж байтал Өвөрхангайн 015 дугаар анги тэр жил татан буугдсан. Тэгээд чамайг хааш нь шингээх вэ гэж ярилцаж байгаад Иргэний хамгаалалтын газрын штабын дарга Банзрагч хурандаа “Чи манайд хэрэгтэй хүн байна. Хоргодох байрны инженерээр ажилла” гэсэн.

Гэтэл газрын дарга Г.Махбариад генерал чамайг шууд төв штабт ажиллуулахгүй. Цэргийн ангид ажиллаж үз, нэг жил болгоод буцааж авна гээд Зэвсэгт хүчний 122 дугаар ангид /одоогийн Үндэсний аврах бригад/ салааны даргаар томилсон юм.

### -Гүүрийн инженер, салаан захирагч болсон түүх ингэж эхэлжээ. Тийм үү?

-Салаан захирагчаар гурван жил ажиллалаа. Нэг өдөр ангийн захирагч дуудаад төв штаб руу биш, ротын захирагчаар томилов. Дахиад нэг жил, хоёр жил чимээгүй. Дуудлаа. Хөдөө орон нутагт яв, Хэнтийн ажил уначихсан тийш яв гээд Хэнтийд 1986-1991 он хүртэл таван жил ажиллав.

Томилогдсон жилдээ Москвагийн Иргэний хамгаалалтын академид зургаан сар суралцаж Иргэний хамгаалалтын штабын офицерын диплом өвөрлөж ирлээ. Хэнтийд ажиллахдаа цас зуд, түймэр, ноосны төлөвлөгөө, аргал түүнээ цуглуулна. Өндөрхаан хөдлөө, нүүрсний цуваанд яв. Шатахуунгүй боллоо, бензин олж ир, бензингүй бол битгий эргэж ирээрэй гэнэ. Түймэр эсэргүүцэх агаарын

харуулын АН-2 онгоцоор ажиглагч нисэгч Баасантай хамт шүхэрчин, гал сөнөөгчдөө аваад ойн түймрийн эргүүлд явна. Нэг удаа хаврын түймэр унтраагаад “хөөтэй төлөг” шиг болсон үед маань Улсын иргэний хамгаалалтын газрын дарга хурандаа генерал Г.Дамдинсүрэн, Иргэний хамгаалалтын төв штабын газар хэлтсийн дарга, ахлах офицерууд хурандаа Г.Чулуун, Батсүх, П. Цэдэв нарын хамт нисдэг тэргээр буудаг юм. Цагийн байдал танилцуулаад рапорт өгсөн чинь хурандаа генерал ихэд тоов. Хэнтий аймгийн Цэргийн хэлтсийн дарга, хурандаа Д.Жадамбаа намайг “Цэргийн хүнээс гадна аймгийн намын хороо, захиргаанд англи хэл заадаг лут залуу байгаа юм” гэж танилцууллаа.

### -Тэгээд буцааж татсан уу?

-НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн шугамаар 1991 онд Тайланд улсад

ажиллах санал тавьсан. Тэгээд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн менежерийн англи хэлний болон гамшигийн менежерийн шалгалтыг Гал гуай болон бусад залуучуудтай өрсөлдөж тэнцэн тус төслийн менежерээр томилогдсон. Гамшгаас хамгаалах төсөл боловсруулах, Монгол Улсад гамшигийн аюулыг бууруулах тогтолцоог боловсронгуй болгох, энэ байгууллагыг шинэчлэх ажил тэр үеэс эхэлсэн.

### -Ярилцлагын эхэнд “бидний байгуулсан” гэж онцолсон нь ийм учиртай байжээ.

-Тийм ээ, төслийн менежерээр 10 жил

юм. Тэр систем нь цаг үетэйгээ нийцэхгүй болсон учраас хуулиа ч систем тогтолцоог ч өөрчлөх шаардлага бий болсон гэсэн үг.

### -Ажлаа юунаас эхэлж байв?

-Юун түрүүнд хуулиа шинэчилсэн. Урьд нь ард нийтээрээ гол төлөв иргэний хамгаалалтын сургууль дадлага хийдэг байсныг өөрчилж төслийн хүрээнд гамшгаас хамгаалах тухай ойлголт өгч, бүх аймаг 330 суманд гамшгаас хамгаалах болон нутгийн иргэдэд тулгуурласан гамшигийн менежерийн сургалт явуулж эхэлсэн. Бүтэц, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг дээшлүүлэх, аврах, анги салбаруудын эрэн хайх, хими, усны

### зудын эрсдэлийг бууруулах арга зам” байсан уу?

-2000-аас өмнөх үед уур амьсгалын өөрчлөлт байгаагүй учраас өвс ногоо нь сайхан ургачихдаг. Зуд бараг болдоггүй байлаа. Гэтэл уур амьсгалын өөрчлөлт хүчтэй нөлөөлж ургамлын гарц муудаад 2000, 2009 -2010, 2021, 2022 оны гэх мэт дараалсан олон зуд болсон. Тиймээс Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд зуд хэрхэн нөлөөлж байгаа талаарх судалгааг хийсэн.

### -Судалгааны дүн яаж гарсан бэ?

-Асар их нөлөөлсөн. Малгүй болсон малчид сум, аймаг, хот руу шилжиж нүүдэл ихэссэн. Заримд нь ажил олдохгүй архи ууж нийгмийн ядуурал бий болсон. Тиймээс зудын гамшиг үндэсний аюулгүй байдалд нөлөөлсөн гэж үзэж бэлчээрийн мал аж ахуйгаа төрөөс дэмжих ёстой гэж үзсэн.

### -Цаашид бэлчээрийн мал аж ахуйгаас эрчимжсэн суурин мал аж ахуйд шилжих талаар ярих болсон. Энэ тал дээр та ямар байр суурьтай байдаг вэ?

-Бэлчээрийн мал аж ахуй монголын уламжлал, соёл бүх юмтай холбоотой. Бэлчээрийн мал аж ахуйгаас ямар ч хог гардаггүй. Хамгийн байгальд ээлтэй. Байгальд ээлтэй мал аж ахуйг авч явна гэдэг өнөө цагт бүр илүү чухал болоод байгаа.

Монгол хүн малаа хариулж байж эрдэм, амьдралын арга ухаанд сурдаг. Малчин хүн 18 төрлийн мэргэжил эзэмшдэг гэдэг. Тухайлбал, малчин хүн наад зах нь хөдөө аж ахуй, газар тариалан, цаг уур, мал зүйч байх нь. Тиймээс бэлчээрийн мал аж ахуй, малчдаа заавал дэмжих ёстой. Харин газар тариалангийн бүсдээ суурин мал аж ахуйгаа дэмжиж цаашид хосолмол байлгах нь зөв.

### -Өнгөрсөн жилүүдэд тохиолдсон зудын сургамж нь юу байв?

-Малаа онд оруулахад арванхоёрдугаар сараас хоёрдугаар сар хүртэл 60 орчим хоног малаа их бага хэмжээгээр тэжээх хэрэгтэй. Үүний 30 хоногийг малчин өөрөө давах, 15 хоногийг сум, 10 хоногийг аймаг, тавыг нь улс даах чадвартай байх ёстой. Ийм тогтолцоог бий болгож, өвс тэжээлийн нөөцөө хуваарилж хэрэгтэй.

Малчид өвс, тэжээл сайн бэлдэх, олон наст ургамлыг, овьёос, ерхөг согоовор бага гэлтгүй газарт өвөлжөө хаваржааны хөл дор тариалах түүнийгээ багсармал тэжээл болгох жижиг

төхөөрөмжтэй болж, таана, хөмүүл, зэргээр гар тэжээл бэлдэж болно.

Хамгийн гол нь малчид аж ахуй эрхлэгч, бизнесмэн болж чадавхжих хэрэгтэй байгаа. Сайн жишээ хэлэхэд, мянган малтай хүн малынхаа суурилах тоог багасгаж 500, 500-гаар нь хувааж маллах, хуц, ухна, төлөх малаа авч үлдэж үлдсэн хэсгээ борлуулсан. Ер нь хээлтэгч болон хээлтүүлэгч малаа аваад үлдчихвэл мал сүрэг нь эргээд амархан сэргэхинэ гэдэг.

### -Гамшигийн эрсдэлийг үнэлдэг болсны давуу тал, ач холбогдол юундаа байна гэж та үздэг вэ?

-Өмнө бол гамшиг боллоо гэхэд дандаа араас нь ажилладаг байсан. Хор уршигийг арилгана гэж. Одоо бол угтаж ажиллахгүй бол араас нь яваад нэмэргүй юм байна гээд Эрсдэлийн удирдлагын газар ажиллаж байна. Угтаж хийхийн тулд аюул, өртөнгө, эмзэг байдал, чадавч нь ямар байна гэдгийг үнэлж мэдэх ёстой. Тэгж байж эрсдэл тодорхой болно. Эрсдэлээ тодорхой болгочигоор стратеги боловсруулж чадна.

Ер нь гамшиг, аюул болдгоороо болно. Харин урьдчилж мэдэж, бодлогоо зөв гаргаснаар урьдчилан сэргийлж учрах хохирлыг бууруулах боломжтой юм..



гамшигийн менежерийн чиглэлээр нэг хүн сургахаар болсон боловч англи хэлэндээ тэнцсэн хүн байгаагүй юм билээ. Боловсон хүчин Ж.Баасанхүү нэг өдөр намайг дуудаж, англи хэлний шалгалт өг гэнсээр шалгалтад ороод тэнцсэн. Тэгээд л өнөө маргаагүй Тайланд яв гээд явуулчихлаа. Тэнд би их юм сурч ирсэн. Буцаж ирээд амралтаа авья гээд ортол Улсын иргэний хамгаалалтын газрын сургалтын төвийн захирлаар томилж, таван жил ажилласан.

### -Дараа нь?

-Завхан аймгийн Тэгшийн гүүрийн барилга дээр ажиллаач гэдэг саналыг Автозамын газрын Тамгын газрын дарга Н.Сүлдчимэг тавьсан. Гэтэл замын маршрут өөрчлөгдөөд Тосонцэнгэлээр дайрах болоод тэр гүүрийг барих шаардлагагүй болсон юм.

Тэгээд ажилгүй гэртээ байж байтал Улсын иргэний хамгаалалтын газрын дарга О.Үржин генерал утасдаад “НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн бэлтгэл шат нь дуусаж, I үе нь эхлэх гэж байна тус төслийг удирдаад явах хүн хэрэгтэй байна” гэж

ажилласан.

Төслийн I шатны захирлаар О.Үржин генерал ажиллаж төслийн суурийг зөв тавьснаар цаашид үйл ажиллагаа нь жигдэрч ажилттай хэрэгжсэн. Төслийн I,II,III үе шатуудад 2002-2012 онд Гамшгаас хамгаалах тухай хуулийн (2003, 2017) төслүүд болон Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, Монгол Улсад гамшигийн аюулыг бууруулах тогтолцоог боловсронгуй болгох, энэ байгууллагыг шинэчлэх ажилд хүчин зүтгэж ажилласан юм.

Дараа нь Дэлхийн банкны Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газарт Гамшигийн эрсдэлийн менежерийн ахлах мэргэжилтнээр 2013-2017 онд мөн ажиллаж ОБЕГ-ыг бэхжүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцаж байлаа.

Тухайн үед Иргэний хамгаалалтын тухай хуульд дайны үед хүн амыг хөнөөх хэрэгслийн хөнөөл болон тайван цагт байгалийн гамшгаас хамгаалах асуудлыг тусгасан байсан

аврах багаж, хамгаалах хувцас хэрэгсэл, техник

тоног, төхөөрөмж хангалтыг нэмэгдүүлэх, бүсийн төв, аймгуудын холбоо зарлан мэдээллийн систем, гамшигийн мэдээллийн сан байгуулж, шуурхай удирдлагын төвийг компьютержуулсан. Хүрээлэн буй орчны аюулгүй байдлын Үндэсний аюулгүй байдалд байгалийн гамшиг нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг хийсэн. Сүүлд сонсох нь ээ ном болж төрийн бүх байгууллага, 330 сумдад тараагдсан гэсэн.

### -Та хүн удирдахдаа ямар зарчим барьж ажилладаг байв?

-Аль болох л дэмжинэ. Хувь хүний өөрийнх нь чадвар дээр үндэслээд дэмжиж ажилладаг. Урам зоригтой ажиллуулаад байвал залуус амжилтад хүрдэг. Дэндүү дарамтлаад байлгүй хүмүүстэйгээ нээлтэй харилцаж давуу талыг нь түшиглээд дэмжиж ажилладаг байсан.

### -Таны докторын зэрэг хамгаалсан сэдэв “Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх



# ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, ШИНЭЭР ЭРСДЭЛ ҮҮСЭХЭЭС СЭРГИЙЛЭХИЙГ ГОЛ ЗОРИЛГОО БОЛГОЖ БАЙГАА Ч ОЛОН СОРИЛТ ТУЛГАРСААР БАЙНА

**-ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МОНГОЛ УЛСЫН ДУНД ХУГАЦААНЫ ТАЙЛАН-**

Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн III бага хурлаас 2015 онд батлан гаргасан "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг"-т 2030 он гэхэд дараах үр дүн, зорилгод хүрнэ гэж тодорхойлсон.

Үүнд:

**ХҮРЭХ ҮР ДҮН:** Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулах.

**ЗОРИЛГО:** Аюулд өртөх байдал, гамшигт эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох бэлэн байдлыг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх. Эдийн засгийн, бүтцийн, хууль, эрх зүйн, нийгмийн, эрүүл мэнд, соёл, боловсрол, байгаль орчны, технологийн, улс төрийн болон институцийн нэгдмэл, харилцан уялдаатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх.

Тус баримт бичгийг дэлхий дахинаа хэрэгжүүлээд зорилтот хугацааныхаа дунд үед хүрээд байна. Энэ хугацаанд Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр авсан улс төрийн үүрэг амлалтаа хэрэгжүүлж, томоохон өөрчлөлт, ололт амжилтад хүрсэн.

- Эрх зүйн хувьд 2017 онд Гамшгаас хамгаалах тухай хуулийг шинэчилсэн бөгөөд энэ шинэчлэл нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд ихээхэн өөрчлөлт, дэвшил авчирсан.

- Бодлогын хувьд үндэсний хэмжээнд "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр", "Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг Монгол Улсын хөгжлийн баримт бичиг болох "Алсын хараа 2050", "Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр"-тэй уялдуулан хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр олон нийт, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, алслагдмал нутгийн иргэдийн гамшгийг даван туулах чадавхыг бий болгоход чиглэсэн арга хэмжээ мэдэгдэхүйц өссөн.

- Орон нутгийн түвшинд, гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилж Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 21 аймаг, нийслэл буюу бүх орон нутаг шинэчилж, Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн "е" зорилтыг хангасан.



Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэхдээ бид өнөөгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэхийг гол зорилго болгон ажиллаж байгаа ч олон шинэ сорилттой тулгарсаар байгаа билээ. Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дунд хугацааны Монгол Улсын тайлан нь 2015-2022 онд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсад олон ололт амжилт, учирсан хүндрэл бэрхшээл, сорилтыг дүгнэн, тулгарч буй асуудлыг цаашид үндэсний болон бүс нутаг, олон улсын хэмжээнд хэрхэн шийдвэрлэж болох арга зам, сайжруулах үйл ажиллагааг тодорхойлох зорилготой бөгөөд дэлхийн хэмжээнд дэвшүүлсэн долоон зорилт, тэргүүлэх дөрвөн чиглэлийн хүрээнд тулгуурлан холбогдох талуудын оролцоотойгоор боловсруулж, НҮБ-д хүргүүлсэн.

Тус дунд хугацааны хэрэгжилтийг дүгнэх, хэлэлцэх, улс орнуудын хэмжээнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, цаашдын арга замыг тодорхойлох зорилгоор

"Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030 баримт бичгийн дунд хугацааны хэрэгжилтийг дүгнэх дээд түвшний уулзалт"-ыг 2023 оны тавдугаар сарын 18-19-ний өдрүүдэд АНУ-ын Нью Йорк хотноо байрлах НҮБ-ын төв байранд зохион байгуулав. Уулзалтад Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Элчин сайд, Байнгын төлөөлөгч В.Энхболд, ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Нийслэлийн ИТХ-ын дарга, Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн дарга Ж.Батбаясгалан, НИТХ-ын Нарийн бичгийн дарга Б.Батбямба, ОБЕГ-ын Эрсдэлийн удирдлагын газрын дарга, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Баасансүрэн тэргүүтэй төлөөлөл оролцлоо. Ингэхдээ тус баримт бичгийн хүрээнд өөрийн улсад авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, ололт амжилт, хүндрэл бэрхшээлийг хуваалцаж илтгэл танилцуулан, салбар хуралдааныг даргалан ажилласан юм.



Үргэлжлэл нь IV нүүрт

"Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил" олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Дотоод хэргийн их сургууль, МУЗН-тэй хамтран /2023.10.20/ зохион байгууллаа. Түүнчлэн ОБЕГ нь тус олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд гадаад улс орноос оролцох эрдэмтэд, судлаачдын оролцоог хангах чиглэлээр дэмжлэг үзүүлэн ажилласан юм. Энэ удаагийн эрдэм шинжилгээний хуралд гадаад, дотоодын нэр хүндтэй эрдэмтэн, судлаачид оролцов. Хурлын үеэр олон улсын болон Монгол Улсын аюулгүй байдал, эрсдэл судлалын хөгжил зэрэг олон сэдвийг хэлэлцсэн. Тиймээс оролцогчдын зарим онцлон хэлсэн үг, байр суурийг хүргэж байна.

**ЭРСДЭЛД СУУРИЛСАН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс ...

**О.Уржин**

УБХИС-ийн Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн зөвлөх, Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор (Sc.D), профессор, хошууч генерал

"Системийн хөгжил болон аюулгүй байдал хоорондоо нягт холбоотой, салангид хэрэгжиж чадахгүй ээдрээтэй диалектик шинжтэй, өөрийн мөн чанар агуулгаар үргэлж сэргэлдэх хандлагатай байх бөгөөд тэр хандлага нь эрсдэлээр дамжин илэрч байдаг."

**ЭРСДЭЛД СУУРИЛСАН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс ...

**Г.Халиун**

БШУЯ-ны Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Боловсролын бодлого, төлөвлөлтийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан

"Гамшиг, болзошгүй аюулын үед ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд учрах эрсдэлийг урьдчилан тооцоолж, сэргийлэх, эрсдэлийг бууруулах, боловсролын үйлчилгээг тасралтгүй, хүртээмжтэй, чанартай хүргэх арга хэмжээг төлөвлөсөн байх шаардлагатай."




**Үргэлжлэл.  
Түрүүч нь III нүүрт**

**МОНГОЛ УЛСАД ТОХИОЛДОЖ  
БУЙ ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ,  
ОСЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Монгол оронд тохиолдож буй аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2015 онтой харьцуулахад бодитой буурахгүй байна (Зураг 1). Нэн ялангуяа уур амьсгалын гаралтай аюулт үзэгдэл 2.9 дахин нэмэгджээ.

Монгол Улсын хэмжээнд 2015-2021 онд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, осол (КОВИД-19 халдварын дата мэдээг оролцуулсан)-ын улмаас нийт 3501 хүн амь насан алджээ. 2022 оны арванхоёрдугаар сарын 31-ний байдлаар КОВИД-19 цар тахлын улмаас 1987 хүн амь насан алдсан байна.

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас амь насан алдсан хүнийг гамшгийн төрлөөр нь авч үзвэл усны осол 55, объектын гал түймэр 28 хувийг эзэлж байна: (Зураг 2). Улаанбаатар хотод амь насан алдсан хүний тоо хамгийн их байна (Зураг 3). Учирсан хохирлын хувьд 2016, 2017, 2018 онд хамгийн өндөр үзүүлэлттэй гарав. (Зураг 5).



**АМЬ НАСАА  
АЛДСАН  
ХҮМҮҮСИЙН  
55 ХУВЬ НЬ  
УСНЫ ОСОЛД  
ӨРТЖЭЭ**




**ГАМШИГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ, ОЙЛГОЛТЫГ  
НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ**

**ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН  
ГАМШИГИЙН ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ**


Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, төрийн өмчийн цэцэрлэг сургуулийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, авто болон төмөр замын үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, ган зудын зэрэг хэд хэдэн төрлөөр

гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг 2016 оны байдлаар зөвхөн 8 хувьд хийсэн байсан бол эрх зүйн орчин бүрдсэнээр 2019 онд 71 хувь, 2020 онд 100 хувь хийж гүйцэтгэлээ. (Зураг 6).



Зураг 2. Амь насан алдсан хүний эзлэх хувь, 2015-2021 оны дундаж (гамшгийн төрлөөр)





Зураг 6. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн байдал

Ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсэгт төрийн байгууллага, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллага, өндөр настан иргэд, тухайн орон нутагтаа удаан жил оршин сууж буй иргэд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг, хүйсийн хувьд эрэгтэй эмэгтэй хүмүүсийг ойролцоо тоотой оролцуулахыг зорьж байна. Ерөнхий үнэлгээгээр улсын хэмжээнд эрсдэлийн зэрэглэл ДУНД дүгнэгдсэн бол, ган "өндөр (60-аас дээш оноо)", хүчтэй салхи шуурга, мал, амьтны гоц халдварт өвчин, газар хөдлөлт, үер зэрэг бусад гамшиг, аюулт үзэгдэлийн эрсдэл "дунд (30-59 оноо)" гэж дүгнэлээ. (Хүснэгт 1).

Ган	Зуд	Хүчтэй салхи	Мал, амьтны халдварт өвчин	Объектын гал түймэр	Үер	Ой, хээрийн түймэр	Усны осол	Газар хөдлөлт
Өндөр 62	Дунд 50	Дунд 50	Дунд 51	Дунд 48.2	Дунд 46	Дунд 36.9	Дунд 39	Дунд 36

Хүснэгт 1. Гамшгийн эрсдэлийн зэрэглэл (гамшгийн төрлөөр)




**АВТО БОЛОН ТӨМӨР ЗАМЫН ГАМШИГИЙН  
ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ:**

Зам, тээврийн салбарын түвшинд олон улс, улсын чанартай авто болон төмөр замд учирч болзошгүй үерийн гамшгийн ерөнхий үнэлгээг аюул, түүнд өртөх магадлал, эмзэг байдал, үерийн аюулыг даван туулах чадавхын үзүүлэлтээр 2020 онд Зам, тээврийн хөгжлийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг хийсэн. Үнэлгээний зураглалаас харахад улсын хэмжээнд авто замд үерийн усанд өртөж болзошгүй 1250 цэг, 1115 км төмөр зам дагуу 52 цэг байгааг тодорхойлсон байна.

**СУРГУУЛИЙН ГАМШИГИЙН ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ**

Хүүхэд өдрийн ихэнх цагийг цэцэрлэг, сургууль дээр өнгөрөөдөг, аливаа гамшгийн үед нэмэлт тусламж шаардлагатай эмзэг бүлэгт хамаарах тул сургууль, цэцэрлэгийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, багш сурагчдын мэдлэг ойлголт, гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх нь нэн чухал асуудал юм. Иймд 2019-2022 онд сургууль, цэцэрлэгийн багш, сурагч, эцэг эхийн оролцоотойгоор аймгийн хэмжээнд төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн 76 хувь, нийслэлийн бүх сургуульд 100 хувь буюу улсын хэмжээнд 85 хувьд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэсэн байна. (Зураг 7). Гамшгийн эрсдэлийг тоймлон тодорхойлоход цэцэрлэг, сургууль харьцангуй өөр өөр үр дүнтэй байгаа боловч улсын дунджаар тооцоолоход газар хөдлөлтийн эрсдэл өндөр, объектын гал түймэр, хүчтэй салхи шуурга, үерийн гамшгийн эрсдэл дунд гэсэн дүгнэлт гарсан байна.



**ГАМШИГИЙН ЭРСДЭЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ**

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг гамшгийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр мэргэжлийн түвшинд нарийвчлан тодорхойлох, болзошгүй хохирлын хэмжээг тооцох, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг төлөвлөх зорилгоор хийж байна. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн шийдвэрээр нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг 2019 онд зургаа, 2020 онд 20, 2021 онд дөрөв, 2022 онд гурав, нийт 33 хуулийн этгээдэд олгосон. Эдгээр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүд 2019 онд 10, 2020 онд 125, 2021 онд 147, 2022 онд 116 буюу нийт 398 аж ахуйн нэгж, байгууллагад гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийж гүйцэтгэсэн.




# ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗАСАГЛАЛ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ

## Бодлогын орчин

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨР

"Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги 2017-2030": Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг өөрийн улсын онцлог, чадавх, нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэхээр гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги" нэртэйгээр батлуулсан. Энэхүү дунд хугацааны стратегийг нэг зорилго, есөн зорилт, үйл ажиллагааны дөрвөн тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2017-2020, 2021-2025, 2026-2030 он хүртэл гурван үе шаттайгаар хэрэгжүүлж байна.



Тус стратегийн эхний үе шат (2017-2020)-ыг төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, шинжлэх ухаан, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийт, олон улсын байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаанд суурилж хэрэгжүүлэхээр Шадар сайдын 2018 оны 23 дугаар тушаалаар нийт 38 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилт 94.2 хувьтай дүгнэгдсэн байна. Үүнд:



Дээрх арга хэмжээний төлөвлөгөөнд хангалтгүй дүгнэгдсэн арга хэмжээнээс "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг хэрэгжүүлэх II үе шат /2021-2025 он/-ны арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж, Шадар сайдын 2021 оны 51 дүгээр тушаалаар батлуулсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсан 56 арга хэмжээг хэрэгжүүлж байна. II үе шатны арга хэмжээ нь стратегийн хэрэгжилтийн гол хэсэг байх бөгөөд I үе шатны арга хэмжээнээс 33 хувиар илүү арга хэмжээг төлөвлөсөн. III үе шатанд стратегийг хэрэгжүүлэхэд олсон амжилтаа бататгах, дараагийн урт хугацаанд хэрэгжүүлэх стратегийн агуулгыг боловсруулахад чиглэгдэнэ гэж үзэж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 8 зорилготой хүчтэй, 5 зорилготой сул, 4 зорилготой уялдаагүй байна. (Хүснэгт 7). Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Алсын хараа-2050, Засгийн газрын мөрийн хөтөлбөр (2020-2024)-тэй 4-6 зорилтын хүрээнд уялдан байна.

Хүснэгт 7 Бодлогын баримт бичгүүдийн уялдаа

№	Бодлого, хөтөлбөр	Бодлогын баримт бичиг хөгжлийн бодлоготой уялдаж буй байдал			Бодлого, хөтөлбөрийн хоорондын уялдаа, холбоо
		Үндэсний аюулгүй байдлын үзэл, баримтлал	Алсын хараа 2050	Засгийн газрын мөрийн хөтөлбөр 2020-2024	
1	Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр /5 зорилт/	4 зорилт	4 зорилт	3 зорилт	2-т заасан хөтөлбөртэй 4 зорилт 3-т заасан стратегитай 5 зорилт
2	Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр /6 зорилт/	3 зорилт	4 зорилт	2 зорилт	1-т заасан бодлоготой 4 зорилт 3-т заасан стратегитай 5 зорилт
3	Сендайн үйл ажиллагааг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги /9 зорилт/	6 зорилт	5 зорилт	4 зорилт	1-т заасан бодлоготой 8 зорилт 2-т заасан хөтөлбөртэй 7 зорилт

Хүснэгт 8 Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратеги, Тогтвортой хөгжлийн зорилгын уялдаа

Уялдан байдал	Тогтвортой хөгжлийн зорилго 2030
<b>Хүчтэй</b>	1, 3, 4, 9, 11, 13, 15, 17 (8)
<b>Сул /зарим</b>	2, 5, 6, 10, 12 (5)
<b>Огт уялдаагүй</b>	7, 8, 14, 16 (4)

Ийнхүү манай улс дэлхий нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний гамшгийг даван туулах чадвараа бэхжүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулснаар Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх амлалтаа хэрэгжүүлэх боломжтой болоод байна.

## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



## "АЮУЛГҮЙ, ГАМШИГТ ТЭСВЭРТЭЙ ХОТ" САНААЧИЛГА МОНГОЛ УЛСАД

Монгол Улсын Засгийн газраас хүн ам бөөгнөрөн сууж буй хот суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулахад анхаарч НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас дэлхийн хотуудын гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох зорилгоор санаачлан хэрэгжүүлж буй "Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот" санаачилгын эхний үе шатанд Монгол Улсын нийслэл Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт хотууд 2016 онд, үлдсэн 18 аймгийн төвүүд 2018 онд нэгдэн орсон. Өнгөрсөн оны арваннэгдүгээр сард тус санаачилгын дараагийн үе шат болох "Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот-2030"-д бүртгэлээ шинэчилж, бүх хотуудаа дахин нэгтгэн орсон. "Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот-2030"-д бүртгэл баталгаажуулах арга хэмжээг цахим, танхим хосолсон хэлбэрээр Төрийн ордонд Шадар сайдын Ажлын алба, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах Зүүн хойд Азийн газар, дэлхийн боловсрол сургалтын хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан. "Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот" санаачилгын хүрээнд 2016-2022 онд ОБЕГ, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Ази, Номхон далайн бүсийн төв, НҮБ-ын Гамшгийн

эрсдэлийг бууруулах Зүүн хойд Азийн газар, дэлхийн боловсрол сургалтын хүрээлэнтэй хамтран 16 удаагийн сургалт, семинар зохион байгуулсан. Сургалт семинар Монгол Улсын бүх хотуудыг хамарч зохион байгуулагдсан. Сургалт, семинарт онцгой байдлын байгууллагын болон бусад холбогдох талуудын шийдвэр гаргах, бодлого төлөвлөлт боловсруулах, бусад гүйцэтгэх түвшний алба хаагчдын оролцоог хангаж ажилласан. Үүний үр дүнд хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг үнэлэх онооны аргыг ашиглан бүх хотуудын чадавхыг 2018-2019, 2022 онд нийт хоёр удаа үнэлсэн. Үнэлгээний дүнгээс харвал 2022 оны үнэлгээ 2018-2019 онд хийсэн үнэлгээний дүнтэй харьцуулахад улсын хэмжээнд 5.7 хувь өссөн үзүүлэлттэй байна. Гамшгийг тэсвэрлэх чадавх дунджаар 15 аймагт 10.7 хувь өсөж, зургаан аймагт 5.3 хувь буурсан үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотын хувьд гамшгийг тэсвэрлэх чадавхын түвшин 2018 онд 49.4 хувьтай үнэлэгдэж байсан бол 2022 онд 52.2 хувьд хүрч, 2.8 хувь өссөн үзүүлэлттэй гарчээ.



Үргэлжлэл нь VIII нүүрт





# МОНГОЛ УЛС ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАН АЖИЛЛАЖ БҮЙ 94 ДЭХ ОРОН

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, орлогч дарга нь онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн буюу Шадар сайд. Зөвлөлийн ажлын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны дарга удирдаж, өдөр тутмын үйл ажиллагааг тус байгууллагын гамшгийн эрсдэлийн удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хариуцаж, орон нутгийн зөвлөлийн дарга нь тухайн шатны ИТХ-ын дарга байхаар тусгав.

Энэхүү зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2019 оны гуравдугаар сарын 6-ны өдөр зохион байгуулж Монгол Улсын Ерөнхий сайд, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дарга гамшгийн эрсдэлийг бууруулахад бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах, оновчтой алсын хараа, эрсдэлийг бууруулах зөв менежментэд суурилсан цогц төлөвлөгөөг хийх, үндэсний болон орон нутгийн зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эрсдэлийг хуваалцах даатгалын механизмыг хөгжүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, шинжилгээнд суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжүүлж, дэвшилтэт техник технологи, инновацыг нэвтрүүлэхэд илүүтэй анхаарч ажиллах талаар гишүүдэд үүрэг чиглэл өгсөн.

Монгол Улсын Ерөнхий сайд, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн даргаар 2020 оны арванхоёрдугаар сарын 18-ны өдрийн 01 дугаар "Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай" 2021 оны зөвлөмжийг батлуулсан. Тус зөвлөмжид нийт 15 бүлэг, 29 арга хэмжээ тусгагдсанаас хэрэгжилт 90 хувьтай дүгнэгдсэн байна. Түүнчлэн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2021 оны ээлжит хуралдааныг долоодугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, хуралдаанаас нийт 24 арга хэмжээ бүхий зөвлөмж, чиглэлийг гаргаснаас хэрэгжилт 83.3 хувьтай дүгнэгдсэн.

Зөвлөлийн 2021 оны ээлжит хуралдаан нь дэлхийн хэмжээнд тархаад буй коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар талхын сөрөг үр дагаврыг даван туулах, урт хугацаанд халдварын эрсдэлийг бууруулах, болзошгүй хүчтэй газар хөдлөлт, гал түймэр, цаг агаарын гаралтай гамшиг, аюулт үзэгдлийн эрсдэлийг бууруулах, барилга, байгууламж, зам, дэд бүтцийн гамшгийг төсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэхэд болон гамшгийн эрсдэлийг бууруулах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн механизмыг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулсан юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2022 оны хуралдааныг аравдугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан бөгөөд энэхүү хуралдаанаар өмнөх хуралдаанаас гарсан шийдвэр, зөвлөмжид тусгасан хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүдэд анхаарлаа хандуулсанаас гадна гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилт, эрсдэлийг шилжүүлэх санхүүгийн механизмыг хөгжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад шинжлэх ухаан, инноваци, харилцаа холбоог сайжруулах зэрэг хэд хэдэн асуудлыг хөндсөн.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий цаашид гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг улсын хэмжээнд үр дүнтэй авч хэрэгжүүлэх зорилгоор дараах



асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

### 1. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

Олон улсын хэмжээнд хүн ам, нийгэм эдийн засаг, хүрээлэн буй орчинд ихээхэн хэмжээний хохирол учруулж болзошгүйд тооцогддог 40 гаруй гамшгаас манай оронд 15 орчим төрлийн аюулт үзэгдэл, осол тохиолддог. Монгол Улсад сүүлийн таван жилийн дунджаар жилд 4660 удаагийн аюулт үзэгдэл, осол бүртгэгдэж, гамшгийн улмаас 202 хүн нас барж, 65.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Гамшгийн тоо давтамж, хамрах хүрээ нэмэгдэхийн хэрээр гамшгаас учрах хохиролын хэмжээ мөн нэмэгдэнэ. Ялангуяа суурьшил тогтмол өсөн нэмэгдэж байгаа төв суурин газрын хүн амд тэр хэмжээгээр учрах аюул, эрсдэлийн түвшин нэмэгддэг. Тиймээс болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх, түүнд шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж, оновчтой зарцуулах шаардлага тулгараад байна.

Энэ хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 51 дүгээр зүйлийн 51.1, 51.2 дугаар заалтад "Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийн 1.0 хувиас доошгүй зарцуулахаар төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төсөвлөж зарцуулах" гэж тусгасан боловч энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд дараах хүндрэл гарч байна.

Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүй хөрөнгийг хэрхэн төсөвлөх, зарцуулах, тайлагнах тухай зохицуулсан, журамласан эрх зүйн баримт бичиг байхгүй, хэрэгжилтийг хангахад талууд өөр өөр ойлголтой байна.

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасан гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарах зардал гэж ташаа ойлгох тохиолдол түгээмэл байгаа нь "Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлын талаарх асуудлыг



тусгайлсан журмаар зохицуулах зайлшгүй шаардлагатай байна.

- Үндэсний болон орон нутгийн зөвлөлөөс гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр тухайн улс, орон нутаг, салбарын түвшинд нэн тэргүүнд, зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж, чиглэл, төлөвлөгөө батлаж байгаа хэдий ч тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх зардал, хөрөнгийг зохицуулах эрх зүйн орчин дутагдалтай байна.

-Хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулж байгааг хэрхэн хянах асуудал тодорхойгүй байна.

### 2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дунд хугацааны хэрэгжилтийн тайланг олон улсад тайлагнасан бөгөөд тус тайланд уур амьсгалын гаралтай аюулт үзэгдлийн хувьд түүний тоо давтамж нэмэгдсээр байгаа бөгөөд 2015 онтой харьцуулахад уур амьсгалын гаралтай аюулт үзэгдэл 2.9 дахин нэмэгдсэн.

Энэ оны долоо, наймдугаар саруудад улсын хэмжээнд гэнэтийн усархаг бороо орсны улмаас нийслэл

Улаанбаатар хот төдийгүй зарим аймаг, орон нутгийн хэмжээнд үерийн аюултай түвшинд хүрч олон мянган айл өрх, аж ахуйн нэгж байгууллага үерт өртсөж, хүн амь нас аалдсан.

Эдгээр үерийн гамшигт өртсөн, орон гэргүй болсон, эд хөрөнгө, амь нас аар хохирсон иргэдийн дунд гамшгийн даатгалд хамрагдсан тохиолдол байхгүй/тун ховор байгаагаас гадна тээврийн хэрэгслийн даатгалд цөөн хувь нь хамрагдсан байна.

Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй ихэнх даатгалын компани эд хөрөнгийн даатгалыг хэрэгжүүлдэг бөгөөд үүнд байгалийн эрсдэлийн даатгал байдаг хэдий ч иргэдийн энэ талаарх мэдээлэл, даатгалын ач холбогдлын талаарх мэдлэг ойлголт дутмаг учир хамрагдсан байдал тун хангалтгүй, мөн манай улсын даатгалын зах зээлд их хэмжээний үнэ бүхий даатгуулагчийг даах чадавх сул байна.

ОБЕГ-аас гамшгийн эрсдэлийн санхүүжилт, эрсдэлийн даатгалын тогтолцоог сайжруулах хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх" техник тусалцааны төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн III зорилтын

хүрээнд Гамшгийн даатгалын хуулийн төслийг боловсруулж байгаа бөгөөд тус хуулийн төсөл батлагдсанаар иргэд, олон нийтийн гамшгийн даатгал, санхүүжилтийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэх, улмаар даатгалд хамрагдсан өрх, аж ахуйн нэгжийн тоо/хувь бодитой нэмэгдэхээс гадна гамшгийн хариу арга хэмжээ, хохирлыг арилгахад зарцуулах зардал бодитой буурах, төрд ирэх дарамт багасах ач холбогдолтой юм.

### 3. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГИЙГ

Сүүлийн жилүүдэд хүчтэй газар хөдлөлт, үер болон бусад гамшгийн тоо, давтамж нэмэгдэх хандлагатай байгаагаас Улаанбаатар хот орчимд эрс өсч, жил бүр эрчимшил ихтэй аадар борооноос үүсэх үерт их, бага хэмжээгээр өртөн хүний амь нас эрсдэх, эдийн засгийн салбар, иргэдийн өмч хөрөнгөнд хохирол учирсаар байна. Эрчимтэй нэмэгдэж буй гамшгаас үүдэн нэн чухалд дэд бүтэц болох эрчим хүчний салбарт гэмтэл гарах, тасалдах,

улмаар шаардлагатай эмнэлгийн үйл ажиллагаа доголдох, ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа зогсох зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулах эрсдэлтэй. Иймд эрчим хүчний салбарын эрсдэлийн үнэлгээг хийж, салбарын хэмжээнд үүсэж болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлт хийх шаардлагатай.

Дээрх хүндрэл бэрхшээлийг харгалзан үзэж Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2021, 2022 оны хуралдаанаар гамшгийн эрсдэлийг бууруулахад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эрсдэлийг хуваалцах механизмыг хөгжүүлэх нь онцгой чухал ач холбогдолтой гэдгийг тодорхойлж "Гамшгийн үр дагаврыг урт хугацаанд даван туулах, цаашид тохиолдож болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн эх үүсвэрийг тодорхой болгож бүрдүүлэх, гамшгийн эрсдэлийн сангийн хуримтлал бий болгож гамшгийн эрсдэл, болзошгүй хохирлыг даатгалын арга хэрэгслээр бууруулах, гамшгийн даатгалын холбогдох хууль тогтоомжийг боловсруулж батлуулах, энэ чиглэлээр даатгалын бүтээгдэхүүн гаргахад төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих" чиглэлээрх арга хэмжээг Сангийн яаманд авч хэрэгжүүлэхээр тусгасан.



# ТУУЛ ГОЛЫН ДАГУУ НАЙМАН БАЙРШИЛД КАМЕР СУУРИЛУУЛСНААР ИРГЭДИЙН УСАНД ОСОЛДОХ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛНА

НИТХ-ын 2022 оны долоодугаар сарын 1-ний өдрийн "Гамшгийн эрсдэлийг бууруулах Нийслэлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай" 69 тогтоолоор шинэчлэн баталсан билээ.

Энэхүү тогтоолын хүрээнд "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2030" бодлогын баримт бичиг болон "Аюулгүй гамшигт тэсвэртэй хот-2030" санаачилгад нэгдэн оров.

Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөл нь өнгөрсөн онд нийт 38 арга хэмжээ, энэ онд 43 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлөөс гаргасан үүрэг чиглэлийн хүрээнд салбар дундын хамтын ажиллагаа, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах засаглалыг сайжруулах арга хэмжээг шат дараатай авч ажиллаж байна. Тус зөвлөл нь есөн дүүргийн салбар зөвлөлүүдтэй бөгөөд уг салбар зөвлөлүүдийг нэгдсэн удирдлага, бодлогоор хангаж, харилцан ажиллах, туршлага солилцох арга хэмжээг 2022 оны тавдугаар сарын 26-ны өдөр "Корпорейт" зочид буудлын "UB Hall" хурлын танхимд зохион байгууллаа. Сургалтад нийт 120 гишүүн хамрагдсан бөгөөд нийт зөвлөлийн гишүүдийн 80 хувийг хамруулж, харилцан туршлага солилцон, цаашид хэрхэн ажиллах арга тактик, стратеги хэлэлцсэн юм.

Мөн 2023 онд зохион байгуулагдсан нэгдсэн сургалтад аймаг, нийслэл, дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн удирдах бүрэлдэхүүн оролцсон нь онцлог байлаа.

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүдээс гаргасан нийтлэг санал дүгнэлт нь орон нутгууд өөр өөрийн онцлогт тохирсон богино хугацаанд хэрэгжих төлөвлөгөө гаргаснаас илүү бүс нутгийн хэмжээнд салбар зөвлөлүүд хамтран хэрэгжүүлэх боломжтой урт хугацаандаа гамшгийн эрсдэлийг хэрхэн бууруулах стратеги төлөвлөгөөтэй болох нь чухал гэж үзэж байлаа.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Нийслэлийн зөвлөлөөс гамшгийг тэсвэрлэх чадавхыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч байгаа бөгөөд нийслэлийн Онцгой байдлын газарт 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу иргэд, олон нийтийн гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгаа, тоног төхөөрөмжийн зардал 100 сая. "Гал түймэр унтраах зориулалтын даралт"-ын хоолой 114.4 сая төгрөгийн өртөг бүхий 51 мм-ийн хоолой 233, 66 мм-ийн 197 нийт 430 ширхэг хоолойг хүлээн авч акт үйлдэв. Тус газрын бүтцийн нэгжүүдийн Гал түймэр унтраах, аврах 15 ангид хүлээлгэн өгч бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажилласан. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах багаж хэрэгсэл / аврах ажиллагааны олс, карбин, каск / 75 сая төгрөг нийт 289.4 сая төгрөгийн гамшигтай тэмцэх чадавхын хөрөнгө оруулалт хийсэн байна.

Тус зөвлөлийн 2023 онд хийсэн томоохон ажлаас цухас дурдвал барилгын паспортжуулалтын санхүүжилтийг зөвлөлийн төсөвт суулган 18 барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргуулан ажиллалаа.

Түр хоргодох байраар ашиглах сургуулийн спорт заалыг иргэд байр-



**-ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НИЙСЛЭЛИЙН ЗӨВЛӨЛ-**



Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүдээс гаргасан нийтлэг санал дүгнэлтээр, орон нутгууд өөр өөрийн онцлогт тохирсон богино хугацаанд хэрэгжих төлөвлөгөө гаргаснаас илүү бүс нутгийн хэмжээнд салбар зөвлөлүүд хамтран хэрэгжүүлэх боломжтой урт хугацаандаа гамшгийн эрсдэлийг хэрхэн бууруулах стратеги төлөвлөгөөтэй болох нь чухал гэв.



**Түр хоргодох байраар ашиглах зориулалттай сургуулийн спорт заалыг иргэд байрлахад бэлдэв.**



**Газар хөдлөлт болон галд тэсвэртэй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн 10 загвар зургийг иргэдэд таниул, үнэ төлбөргүй түгээв. Уг загварууд эрчим хүчний хэрэглээний ангиллаар А+ ангилалт хамаарч гэрчилгээ авсан.**

лахад бэлдэж, шаардлагатай хэрэгслээр НОБГ/202305001 дугаартай тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгууллаа. Гэрээгээр 244 ширхэг эвхдэг ор, хөнжил, гудас, хоолны иж бүрдэл сав хүлээж авсан бөгөөд болзошгүй гамшгийн үед иргэдийн анхдагч хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлэн ажиллав.

Болзошгүй гамшгийн үед түр цугларх 192, нүүлгэн шилжүүлэх 31 байршлыг НИТХТ-ийн 2016 оны 94, 2020 оны 17 дугаар тогтоолуудаар баталгаажуулсан. Дээрх тогтоолуудыг шинэчлэх зайлшгүй шаардлагын хүрээнд 203 байршлын 164.61 га талбай, нүүлгэн шилжүүлэх 33 байршлын 1430.4 га талбайг шинэчлэн 2023 оны зургаадугаар сарын 22-ны өдрийн НИТХ-ын ээлжит бус XII хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан бөгөөд мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Газар хөдлөлт болон галд тэсвэртэй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн 10 загвар зургийг иргэдэд таниулах, үнэ төлбөргүй түгээх ажлыг зөвлөлөөс зохион байгуулан ажиллалаа. Иргэд, олон нийт өөрсдийн төсөв, санхүүгийн байдалд тохируулан 40м², 60м², 80м², 100м², 120м² сонголттой бөгөөд уг загварууд нь эрчим хүчний хэрэглээний ангиллаар /А+ / ангилалт хамаарч гэрчилгээ авсан байна.

Тус зөвлөлөөс өндөр нарийвчлалтай найман камерыг иргэд олноор цуглардаг, голын эрсдэлтэй цэгүүд, үер, гол усны осол болон эрсдэлийг бууруулах зорилгоор гурван км радиуст харагдах хүчин чадалтай нарны зайн хураагууртай, чанга яригчтай иж бүрэн камер суулгахаар гэрээ байгуулан ажиллаж байна.

Уг камерууд нь Туул гол дагуу иргэд осолдох эрсдэлтэй /Баянзүрх дүүргийн XX хороо Минж үржүүлэг, 85 дугаар сургуулийн урд, Хар усан тохой, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо Зэл амралт, Мишээл экспо урд, I хороо Зайсангийн гүүрний доор, Яармагийн гүүрний доор найман байршилд суурилуулснаар иргэдийн усанд осолдох эрсдэлийг бууруулаа.

Нийслэл хотод хүн амын нягтрал нэмэгдэхийн хирээр гал унтраах аврах ангийн тоог зайлшгүй нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна. Тиймээс тус зөвлөлөөс "Хүн амын нягтрал ихтэй байршилд гал түймэр унтраах, аврах анги шинээр байгуулахтай холбогдуулан холболтын зураг боловсруулах" иж бүрэн зураг, төсвийг "Орионт плюс" компанитай гэрээ байгуулж хэрэгжүүлэв.

Өнгөрсөн оны цар тахлын үед долоон чиглэлээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний биелэлт 81.3 хувьтай биелсэн гэж дүгнэлээ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Нийслэлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа А.Дашням нийслэлийн хэмжээнд гамшгийг тэсвэрлэх чадавхыг дээшлүүлэхэд гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилт, даатгал, нотолгоонд суурилсан сэргээн босгох төлөвлөлт хийх зайлшгүй шаардлагатайг онцлон хэлэв.



**2022 онд зохион байгуулсан нэгдсэн сургалт**



# ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, ГАМШГИЙГ ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ

Үргэлжлэл. Түрүүч нь I, III, V нүүрт

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал нь улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай болон нөөц сангууд, засгийн газар хоорондын хөнгөлөлтэй зээл, тусламж, Монгол Улсад гамшгийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын санхүүжилт болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж зэрэг эх үүсвэрээс бүрддэг.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор УИХ-аас 2017 онд

шинэчлэн баталсан Гамшгаас хамгаалах тухай хуульд "гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн байгууллага тухайн жилийн төсвийн 1-ээс доошгүй хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төсөвлөж зарцуулна" гэсэн заалтыг нэмж тусгасан.

Гамшгаас хамгаалах тухай хууль (2017)-д гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн хор уршгийг арилгах, гамшгийн дараах сэргээн босгох үйл ажиллагаанд төсөвлөгдөхөөр тусгаж санхүүжилтэд дараах өөрчлөлт оруулсан.

+

Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
-	Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана.
Гамшгийн голомтод аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулахад гарах зардлыг төрийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, байгууллагын хувьд төр хариуцна. Бусад аж ахуйн нэгж, байгууллагын хувьд гамшигтай холбогдсон зардлаа өөрөө хариуцна.	Гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүй зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна.
Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, аж ахуйн нэгж, байгууллага зардлаа өөрөө хариуцна.	Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захирагчид байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна.

Хүснэгт 12. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтын харьцуулалт, Гамшгаас хамгаалах тухай хууль 2003, 2017



Зураг 15. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төсвийн хэмжээ

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар улсын төсвийн санхүүжилттэй засаг захиргааны нэгж, аж ахуйн нэгж, байгууллага болон хуулийн этгээдийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулах төсвийг тодорхой хувь хэмжээгээр тогтоож өгч, мөн гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд санхүүжилтийг зарцуулахыг хуульчилснаар гамшгаас хамгаалах

үйл ажиллагааны санхүүжилтийн эрх зүйн орчинг сайжруулсан байна.

Энэ хүрээнд Монгол Улсын 21 аймгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулахаар тусгасан төсвийн хэмжээ 2018 онд 2.3 тэрбум төгрөг байсан бол энэ тоо 2022 онд 10.4 тэрбум төгрөг болж 4 дахин нэмэгджээ.

(Зураг 15).

## 2015-2021 ОНД ЗАРЦУУЛСАН ХОР УРШГИЙГ АРИЛГАХ ЗАРДЛЫН ХУВЬД

- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газраас төлөвлөж зарцуулсан хөрөнгө 88.4 хувиар нэмэгдсэн байна (КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээнд зарцуулсан зардал багтсан).
- Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагаанд болон малын нөхөн төлбөр 48 хувь буурсан,

- Үер, хүчтэй аадар бороо, салхи шуурга зэрэг байгалийн аюулт үзэгдлийн улмаас учирсан хохирлыг арилгах, сэргээн босгох зардал 80.9 хувь буурсан,
- Өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зудын хохирлыг бууруулах зорилгоор улсын нөөцөөс зарцуулсан өвс, тэжээл бүрдүүлэх зардал 9.2 хувь өссөн,
- Улсын нөөцөөс олгосон автомашин, гэр, дулаан хувцас, бусад бараа материалын нөхөн бүрдүүлэх зардалд 89 хувь нэмэгдсэн байна.

## ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ХОР УРШГИЙГ АРИЛГАХ, САЙЖРУУЛАН СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГААНД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ

### ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө болох "Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө" нь Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор батлагдсан. КОВИД-19 халдварын үед энэхүү төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн улсын алба ажилласан.

Үүнээс Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар", ОБЕГ-ын даргын 2019 оны А/388 дугаар тушаалаар батлуулсан

"Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах загвар"-ыг онцолж. Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна, гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний үндэслэл болно гэж тусгасан.

Энэ хүрээнд I/ аймаг, нийслэл, сум дүүргийн, II/ гамшгаас хамгаалах албаны, III/ байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг боловсруулсан. Төлөвлөгөөний бүтцийг Хүснэгт 14-т харуулав.

Хүснэгт 14. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц

	Аймаг, нийслэл, сум дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө	Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө
1.	Нийтлэг үндэслэл	Нийтлэг үндэслэл	Нийтлэг үндэслэл
2.	Танилцуулга	Танилцуулга	Танилцуулга
3.	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө	Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө
4.	Хариу арга хэмжээний төлөвлөгөө -гамшгийн аюулт үзэгдэл, ослын төрөл бүрээр хийнэ I.Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах төлөвлөгөө II.Гамшгаас хамгаалах дайчилгаа зохион байгуулах төлөвлөгөө III.Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө	Хор уршгийг арилгах арга хэмжээний төлөвлөгөө -гамшгийн аюулт үзэгдэл, ослын төрөл бүрээр хийнэ	Аюулт үзэгдэл, ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө
5.	Сэргээн босгох төлөвлөгөө	Сэргээн босгох төлөвлөгөө	Аюулгүйн цэгт цугларах төлөвлөгөө
6.	Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах төлөвлөгөө		
7.	Хавсралт	Хавсралт	Хавсралт
8.	Бүтцэд нэмэлт хэсэг оруулж болно.		

Засаг захиргааны нэгжийн болон гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөний тавдугаар бүлэг нь сэргээн босгох төлөвлөгөө юм. Тус төлөвлөгөөнд КОВИД-19 халдварт цар тахалтай холбогдуулан тодотгол

хийгдсэн байна.

Цаашид гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, дадлагажуулах чиглэлээр дасгал сургууль тогтмол зохион байгуулах зүйтэй.



## ӨНДӨР УУЛАНД ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ АРГА ТЕХНИК САЙЖРАВ

Монгол Улс хойд болон баруун талаараа уулархаг, Алтай нурууны ноён оргил Алтай таван богд уулын "Хүйтний оргил" далайн төвшнөөс 4374м, хангайн нурууны ноён оргил "Отгонтэнгэр" 3095м өндөр мөнх цастай уул юм. Монгол Улсад 1961 онд Увс аймгийн Түргэний ууланд 10 гаруй уулчид осолдож нэг уулчин амь насаа алдаж байсан. Үүнээс хойш 2015-2022 оны хугацаанд өндөр ууланд цасан нурагид дарагдсан хоёр том осол тохиолдсон.

Энэхүү том ослын үеэр эрэн хайх, аврах ажиллагаанд ОБЕГ, Үндэсний аврах бригад, орон нутгийн Онцгой байдлын газрын алба хаагчид, нэмэлтээр Цагдаагийн байгууллага, Хилийн цэргийн дугаар анги, уулын авиралтын тамирчид зэрэг 2015 онд 25 гаруй хүн, гурван техник хэрэгсэл, нэг нисдэг тэрэгтэй, 2017 онд 254 гаруй хүн, 43 техник хэрэгсэл, хоёр нисдэг тэрэг оролцсон юм.

Эрэн хайх, аврах баг цаг агаарын хүндрэлтэй байдлаас шалтгаалан ихээхэн сорилттой тулгарч байсан ч ослын эрэн хайх аврах ажиллагааг амжилттай зохион байгуулж чадав.

Дараалан тохиолдсон хоёр том осолд ажилласан туршлага, сургамжид суурилан ОБЕГ өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагаа явуулах чиглэлээр гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрх зүйн баримт бичгийг сайжруулах, ууланд аврах ажиллагаа явуулах аврагчдын ажиллагааны арга техникийг сайжруулах, дадлагажуулах, стандарт бүхий хувцас, багаж хэрэгсэлээр хангах зайлшгүй шаардлага байгааг тодорхойлов.

Цаашид уулын спортыг сонирхож ууланд алхах, авирах хүмүүсийн тоо нэмэгдэж байгатай холбогдуулан уулчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах ойлголт, мэдлэг илүүтэй олгох, батлагдсан журмын дагуу аврагчдад дадлага сургалт зохион байгуулах, стандартын хамгамалтын хувцас, багаж төхөөрөмжөөр хангах хэрэгцээ, шаардлага байна.

Өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагаа явуулах дадлага сургалтыг олон улсын аврагчидтай анх удаа 2018 оны наймдугаар сард зохион байгуулсан. Сургалтад ОХУ, БНКиригиз Улс, Монгол Улсын аврагчид, Монголын уулчдын баг, Эвсэгт хүчний дугаар анги зэрэг өргөн бүрэлдэхүүнтэй оролцсон. Үүнээс хойш хэд хэдэн дадлага сургалтыг зохион байгуулж аврагчдад бэлтгэж байна.

Эрх зүйн баримт бичгийн хувьд ОБЕГ-ын даргын 2019 оны аравдугаар сарын 30-ны өдрийн А/330 дугаар тушаалаар "Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам" -ыг батлуулсан.

Цаашид уулын спортыг сонирхож ууланд алхах, авирах хүмүүсийн тоо нэмэгдэж байгатай холбогдуулан уулчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах ойлголт, мэдлэг илүүтэй олгох, батлагдсан журмын дагуу аврагчдад дадлага сургалт зохион байгуулах, стандартын хамгаалалтын хувцас, багаж төхөөрөмжөөр хангах хэрэгцээ, шаардлага байна.



# ГАМШГИЙН ҮЕД АШИГЛАХ УЛААНБААТАР ХОТОД БАЙРЛАХ ТҮР ЦУГЛАРАХ ТАЛБАЙ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРШИЛ, ТҮР БАЙР

Газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 94, 2020 оны 17 дугаар тогтоолоор түр цугларах талбай 192, нүүлгэн шилжүүлэх 31 байршлыг томилгоожуулсан.




192 түр цугларах талбай (цэг) нь 442300 м.кв талбай газрыг эзэлж байна. Тус түр цугларах талбайд болзошгүй гамшгийн аюулт үзэгдэл, ослын үед 300 мянга орчим хүнийг гаргаж аюулгүй байдлыг хангана гэж төлөвлөөд байна.



## НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРШИЛ

НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан 31 байршилд түр байраар ашиглах 478 түр сууцанд 5820 хүнийг байрлуулна гэж төлөвлөж байна.



## ТҮР БАЙР

Нийслэлийн хэмжээнд 2002 оноос хойш баригдсан газар хөдлөлтийн 7-8 баллын газар хөдлөлтөд тэсвэртэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үндсэн байр болон спорт заал, зочид буудлын барилга, амралт аялал жуулчлалын газар зэрэг нийт 344 барилга байгууламжийг түр байраар ашиглана гэж төлөвлөсөн.

Энэ хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн "Улаанбаатар хотын бага, дунд боловсролын сургуулийн барилга байгууламжийг сайжруулах" (The project for the Improvement of Facilities for Primary and Secondary Education in Ulaanbaatar City in Mongolia) төслийн хүрээнд Улаанбаатар хотын хоёр сургуулийн барилгыг шинээр, мөн тооны сургуулийн барилгад өргөтгөл баруулав.

Тус дөрвөн сургуулийн барилга нь Монгол Улсад сургуулийн барилгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй, гамшигт тэсвэртэй, гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх түр байраар ашиглах боломжтой, байгаль орчинд ээлтэй жишиг сургуулийн барилга болсон. Тус бүр 18 тонн усны нөөц сав, хүнсний болон бусад төрлийн нөөц хадгалах агуулах, цахилгааны нөөц үүсгүүртэй тул газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед иргэдийг байрлуулах бүрэн боломжтой.



## ГАМШГИЙН ҮЕД АШИГЛАХ ЗОРИУЛАЛТААР БАРЬСАН ШИНЭ СУРГУУЛИУД:

- 2020 онд 720 хүүхдийн хүчин чадалтай Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 149 дүгээр сургууль
- 2021 онд 920 хүүхдийн хүчин чадалтай Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 75 дугаар сургууль Өргөтгөл баригдсан сургууль:
- 2020 онд 480 хүүхдийн хүчин чадалтай Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 53 дугаар сургууль

- 2020 онд 320 хүүхдийн хүчин чадалтай Налайх дүүргийн ерөнхий боловсролын 109 дүгээр сургууль НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Монголын Улаан загалмай нийгэмлэгээс 75, 149 дүгээр сургуулийг гамшгийн үед түр байраар ашиглах нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Цаашид аймаг, сумын хэмжээнд түр байраар ашиглах боломжтой барилга байгууламжийг томилгоожуулан, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх шаардлагатай.

## 2.4.6. ЭРТ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ СИСТЕМ

Гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх системийг хөгжүүлэхэд Монгол Улс анхаарал хандуулж ирсэн хэдий ч гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх системийн бэлэн байдлыг хангахад хүндрэл бэрхшээлтэй хэвээр байна.


ОБЕГ дэргэдэх Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн гамшгийн аюулыг зарлан мэдээлэх систем нь 2013 онд ашиглалтад орсон. Тус систем нь газар хөдлөлт болон бусад аюулт үзэгдлийн үед ШУА-ын Одон орон геофизикийн хүрээлэн, Цаг уур орчны шинжилгээний газраас мэдээ мэдээллийг хүлээн авч Улаанбаатар хотод суурилуулсан хэт богино долгионы дахин дамжуулах дөрвөн

бааз станцаар дамжуулан дуут дохиоллын 60 ширхэг цамхаг, өргөн нэвтрүүлгийн гурван телевиз, арван FM радиогоор гамшгийн аюулыг анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг иргэд, олон нийтэд дамжуулахаар зохион байгуулсан.

Үүрэн холбооны оператор компаниудаар дамжуулан иргэд, олон нийтэд гамшгийн аюулын тухай багц мессеж, сэрэмжлүүлэг хүргэх үйлчилгээ технологийн дэвшил (4G, 5G)-ээс хамааран хоцрогдолтой болох нөхцөл бий болсон. Ерөнхийдөө гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн хөгжүүлэлтийн 2022 оны байдлыг 2015 онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт. 15 Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийн нөхцөл байдал

	2013 он	2022 он
Дуут дохиоллын цамхагийн тоо	60	50
Өргөн нэвтрүүлгийн телевизийн тоо	3	2
FM Радио станцын тоо	10	6



Зураг 16 Нийслэлийн хэмжээнд байгаа түр цугларах талбайн байршил Эх сурвалж: <http://manaikhoroo.ub.gov.mn/>



# “ӨСВӨРИЙН АВРАГЧ-2023”

## УЛСЫН УРАЛДААН БАГАНУУР ДҮҮРГИЙН 66 ДУГААР СУРГУУЛИЙН ДӨЛ БҮЛГЭМ ТЭРГҮҮЛЭВ



Тэргүүн байрын эзэд - Улаанбаатар бүсээс оролцсон Багануур дүүргийн ерөнхий боловсролын 66 дугаар сургуулийн "Дөл" бүлгэм

Онцгой байдлын ерөнхий газар, Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, Боловсролын ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, аймаг нийслэлийн Боловсролын газартай хамтран "Өсвөрийн аврагч-2023" улсын уралдааныг /2023.10.14/ амжилттай зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаа нь хүүхэд, багачуудын гамшгаас хамгаалах мэдлэг, хандлага, чадварыг нэмэгдүүлэх, аюулгүй амьдрах арга ухаанд суралцуулах зорилготой. Мөн болзошгүй аюул ослын үед өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, хүнлэг энэрэнгүй иргэн болгон төлөвшүүлэхэд сургадаг онцлогтой. Энэ удаагийн улсын уралдаанд бүс, бүсээс шалгарсан зургаан багийн 50 орчим өсвөрийн аврагч оролцсоноос Улаанбаатар бүсийн Багануур дүүргийн ерөнхий боловсролын 66 дугаар сургуулийн "Дөл" бүлгэм авхаалж самбаа, хурд хүчээр илүүрхэж тэргүүлээ.

Тэмцээнд Улаанбаатар бүсээс шалгарсан Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн "Мазаалай", Багануур дүүргийн ерөнхий боловсролын 66 дугаар сургуулийн "Дөл" бүлгэм, Зүүн бүсээс шалгарсан Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын I сургуулийн "Шонхор" бүлгэм, Баруун бүсээс шалгарсан Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын II сургуулийн "Шонхор" баг, Хойд бүсээс шалгарсан Төв аймгийн "Хүмүүн" цогцолбор сургуулийн "Хүмүүн" бүлгэм, Өмнөд бүсээс шалгарсан Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын II сургуулийн "Соёмбо" бүлгэм оролцов. Нээлтийн ажиллагаанд ОБЕГ-ын тэргүүн дэд бөгөөд штабын дарга, бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн, МУЗН-ийн ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Т.Баярчимэг, "Дэлхийн Зөн Монгол" ОУБ-ын үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Цолмон нар оролцож, оролцогчдод амжилт хүсэж үг хэлсэн. Бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн "Хүсэл зорилго, итгэл найдвар, мөрөөдөлтэй, түүндээ хүрэх тэмүүлэл, боловсрол мэдлэг бүхий залуу үетэй байна гэдэг эх орны ирээдүй гэрэл гэгээтэй байгаа гэсэн үг юм. Тийм залуу үеийн, эх орны гэрэлт ирээдүйн төлөөлөл бол энд хуран цугларсан та бүхэн гэдэгт би итгэлтэй байна" гэлээ.



Дэд байр- Зүүн бүсээс шалгарсан Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын I сургуулийн "Шонхор" бүлгэм




Гуравдугаар байр- Баруун бүсээс шалгарсан Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын II сургуулийн "Шонхор" бүлгэм

Өсвөрийн аврагчид жагсаалын үзлэг, мэдлэг сорих асуулт хариулт, уснаас аврах ажиллагаа, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, хүч тамирын болон химийн хордолт, гал унтраах цэгүүдэд үүрэг гүйцэтгэж, оюун ухаан, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, аваргуудаа шалгаруулсан.

Мөн энэ үеэр Онцгой байдлын байгууллагад ашиглаж байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгслийн үзэсгэлэн олны хүртээл болгов.

Онцгой байдлын байгууллагаас Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр" -ийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулан улсын хэмжээнд 487 бүлгийн 3820 сурагчийг өсвөрийн аврагчаар бэлтгээд байна.





МЭДЛЭГИЙН САНД

# ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


**Эрсдэлийн удирдлагыг гамшгаас хамгаалах удирдлагад нэвтрүүлэх асуудал бол харьцангуй шинэ хандлага, үзэл баримтлал билээ.**  
**Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь болзошгүй эрсдэлд хяналт тавьж түүнийг удирдахад оршино. Энэ зорилго нь эрсдэлийн удирдлагын хүрээнд тодорхойлогдсон багц арга хэмжээгээр хэрэгжинэ.**

**Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь болзошгүй эрсдэлд хяналт тавьж түүнийг удирдахад оршино. Энэ зорилго нь эрсдэлийн удирдлагын хүрээнд тодорхойлогдсон багц арга хэмжээгээр хэрэгжинэ.**

Гамшгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь боломжтой тохиолдолд аюул тохиолдохоос сэргийлэх, эсвэл бодлогын болон инженер техникийн оновчтой шийдэл, аюулд тэсвэртэй барилга байгууламж, түүнчлэн хүрээлэн буй орчинтой зохистой харьцах, олон нийтэд зөв мэдээлэл, мэдлэг өгөх зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарсан арга хэмжээг авч хэрэгжүүлж аюулд өртөх нийгмийн эмзэг байдлыг бууруулах замаар хохирлын хэмжээг багасгахад оршино. Энэ үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийн үнэлгээ хийх, аюулын магадлал, түүнд өртөх эмзэг байдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн болзошгүй аюулын сөрөг нөлөөллөөс зайлсхийх, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ хамаардаг.

Гамшгийн эрсдэлийн удирдлагын үйл явц нь эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, үнэлэх, бууруулах, хянах болон нөхцөл байдлыг тодорхойлох, харилцан хамтарч ажиллах үйл ажиллагааг тодорхой бодлого чиглэлтэйгээр цогцоор хэрэгжүүлэх гэсэн өөр хоорондоо уялдаатай зурагт заасан үйл явцаас бүрдэнэ.

Манай улсын хувьд гамшгийн эрсдэлийн үнэлгээг ерөнхий болон нарийвчилсан гэсэн 2 төрлөөр хийх эрх зүйн зохицуулалттай.



Зураг. Гамшгийн эрсдэлийн удирдлагын үйл явц

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлийн түвшинг тодорхойлж, үзүүлж болзошгүй нөлөөллийн хэмжээгээр нь зэрэглэн, эрсдэлийг бууруулах шаардлагатай арга хэмжээг тодорхойлно.

## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Гамшгийн эрсдэлийг бууруулах нь эхний ээлжинд болзошгүй аюулын тохиолдох магадлал, түүнд өртөх байдал, эмзэг байдлыг бууруулж аюулын сөрөг нөлөөллийг багасгах, харин буурах боломжгүй олон хүчин зүйлсээс шалтгаалсан үлдэгдэл эрсдэлийг удирдах чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ авах гэсэн асар өргөн хүрээний асуудал юм.

Эрсдэлээс бүрэн гүйцэд ангижирч чадахгүй ч түүний хамрах хүрээ, хор хөнөөлийн хэмжээг олон төрлийн стратеги, арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд бууруулж чадна.

### Эрсдэл тохиолдох магадлалыг багасгах

Тохиолдох нь нэгэнт тодорхой байгаа аюулын тохиолдох тухайн боломжийг бууруулж болно. Өөрөөр хэлбэл эдгээр аюулын тохиолдох магадлалыг нь багасгахад эрсдэлийн түвшин буурна. Гэхдээ аюул бүрийн

хийц бүтээцийг хүчтгэхэд чиглэсэн арга хэмжээнүүд байдаг. Технологийн аюулын тухайд бол аюулгүй байдлыг сайтар хангаснаар эрсдэлээс хүлээх үр дагаврыг багасгаж болно.

### Эрсдэлээс зайлсхийх

Зарим эрсдэлүүд түүний магадлал ба үр дагаврын аль алиныг нь ямар нэг байдлаар багасгасан ч ноцтой байдал нь хэвээр хадгалагдаж үр дүн нь эрсдэлийг хүлээн авах түвшинд хүрэхгүй байдалтай байдаг. Эдгээр эрсдэлийн хувьд магадлал ба үр дагаврыг нь багасгах арга хэмжээ авах шаардлагагүй тул түүнээс зайлсхийх нь үр дүнтэй.

Байгалийн аюулт үзэгдлийн хувьд эрсдэлээс зайлсхийхын тулд ихэвчлэн тухайн аюулын нөлөөлөлд өртөх газраас нүүх арга хэмжээ авдаг. Газар хөдлөлт зэрэг их хэмжээний газар нутгийг хамарсан аюулын хувьд эрсдэлээс зайлсхийх нь боломжгүй зүйл юм. Харин тодорхой газар нутгийг

Хоёрдугаарт, зарим эрсдэлийг бууруулах арга хэмжээ нэг ба түүнээс олон хүсээгүй үр дагаварт хүргэж болно. Ийм хоёрдогч эрсдэл нь аюултай нөхцөлийг бий болгож хүсч байсан үр дүнг бууруулдаг эсвэл хүсээгүй үр дагавар нь эрсдэлийг бууруулах арга хэмжээний шууд үр дүн байдлаар гарч ирэхээр байж болно. Аль ч тохиолдолд хоёрдогч үр дагавар одоогийн аюулын эрсдэлийн үр дагавраас илүү аюултай нөхцөлийг бий болгож, тодорхой бус байдлыг нэмэгдүүлж болно.

### Эрсдэлийг шилжүүлэх, хуваах эсвэл тархах

Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар хамгийн түгээмэл хэрэглэгддэг стратеги нь эрсдэлийг шилжүүлэх, хуваах, тархах юм. Энэ стратегийн гол санаа нь эрсдэл буурахгүй, гэхдээ нэрвэгдэгч бүрт дундаж үр дагавартай байхаар том бүлгийн хүрээнд түүний магадлал, үр дагаврыг сулруулах явдал юм.

Эрсдэлийг шилжүүлэх хамгийн түгээмэл хэлбэр бол даатгал, олон улсын давхар даатгал юм. Даатгал нь эд хөрөнгийн мөнгөн хэмжээний хохирлыг арилгаж эрсдэлийн санхүүгийн үр дагаврыг бууруулдаг. Даатгуулагчид аюулын хүлээгдэж буй магадлал, үр дагаварт үндэслэж тогтоосон даатгалын хураамжийг төлдөг. Энэ нь тухайн даатгуулсан аюул тохиолдсон үед хохирлоо нөхөн төлүүлэх баталгаа болно. Гамшгийн хохирол энэхүү даатгалын хураамжийг төлсөн бүх хэрэглэгчдэд хуваагдана. Нэрвэгдсэн, нэрвэгдээгүй ялгаагүйгээр ижил хураамж төлж гамшгийн үр дагаврыг цуглуулсан хамтын сангаараа даван туулдаг.

### Үлдэгдэл эрсдэлийн удирдлага

нь бууруулж болохгүй, мөн урьдчилан сэргийлэх боломжгүй эрсдэлд буюу үлдэгдэл эрсдэлд чиглэсэн бодлого, үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Энэ төрлийн эрсдэлийг хор уршгийг арилгах арга хэмжээ авах, сэргээн босгох арга замаар удирддаг. Харин бэлэн байдлыг хангах нь үлдэгдэл эрсдэлийг үр дүнтэй удирдахад тус болно.

Үлдэгдэл эрсдэлийн удирдлагад нь дараах арга хэмжээнүүд багтана. Үүнд:

- Бэлэн байдлын төлөвлөгөө
- Сургалт, дадлага хийх
- Эрт зарлан мэдээлэх системийг бий болгох
- Нүүлгэн шилжүүлэх
- Хор уршгийг арилгах арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх
- Нөөцийн хадгалалт, түгээлт

Гамшгийн эрсдэлийн удирдлагыг 3 үе шаттай арга замаар хэрэгжүүлнэ гэж үзэж болно. Үүнд: Эрсдэлийн тухай ойлголтоотой болох, дараа нь эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, сүүлд нь үлдэгдэл эрсдэлийг удирдах (Кумар, 2014).

**Эх сурвалж: ОБЕГ, БОАЖ-НЫ АДАПТ төсөл, "Гамшгийн эрсдэлийн удирдлага" Гарын авлага, 2023**



хувьд тохиолдох магадлалыг нь багасгах боломжгүй. Тухайлбал, байгалийн аюулт үзэгдлийн хувьд тохиолдох магадлалыг бууруулах боломж хүний үйл ажиллагаатай холбоотой ослыг бодвол харьцангуй бага.

Технологийн болон хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой аюулууд нь хүний үйл ажиллагаа, тэдгээрийн шийдвэртэй холбоотой байх учраас аюулын магадлалыг багасгахад чиглэсэн арга хэмжээг өргөнөөр хэрэглэж болно.

### Эрсдэлийн үр дагаврыг багасгах

Гамшгийн эрсдэлийг бууруулах хүрээнд зайлшгүй хийгдэх хоёр дахь зүйл бол хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учрах аюулын нөлөөллийг буюу хор уршгийг багасгах явдал юм. Аюулын нөлөөллийг багасгах арга хэмжээ нь тодорхой хэмжээний эрч хүчтэй аюул тохиолдоход түүнийг ямар нэг сөрөг үр дагаваргүйгээр тэсвэрлэж гарч чадахаар хүн ам, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авахад бүхэлдээ чиглэгдэнэ.

Ихэнх аюулын хувьд аюулын магадлалыг багасгахтай харьцуулахад аюулын үр дагаврыг багасгах эд хэдэн сонголтууд байдаг. Байгалийн аюулт үзэгдлийн хувьд эдгээр арга хэмжээ хүний амь насыг хамгаалах,

хамарч тохиолдох үер, хүчтэй салхи гэх мэт аюулын хувьд эрсдэлээс зайлсхийх боломжтой бөгөөд энэ тохиолдолд тухайн аюулд өртөх боломжтой бүх зүйлийг зайлуулж, дахиж тухайн газарт барилга, байгууламж барих, суурьшихыг хориглож болно.

Эрсдэлээс зайлсхийх стратегийг тухайн эрсдэлийг хүлээж авбал нийгэмд маш ноцтой аюул учруулж болохуйц технологийн ослын хувьд ихэвчлэн хэрэглэгддэг.

### Эрсдэлийг хүлээн авах

Зарим нэг тодорхой аюулын хувьд тухайн нийгэм ба хувь хүн тодорхой эрсдэл байхыг хүлээн зөвшөөрдөг. Энэ тохиолдолд тухайн эрсдэлийг бууруулах шаардлагагүй эсвэл эрсдэлийг бууруулах зардал хэт өндөр байна. Энэ шийдвэрт хүргэх хэд хэдэн шалтгаан байж болно.

Нэгдүгээрт, улс орон, бүс нутаг ба орон нутаг бүрт тэмцэхээс өөр аргагүй эсвэл тухайн аюулыг бууруулах арга хэмжээ авахад шаардлагатай хөрөнгө, санхүү хангалтгүй байх аюулууд байдаг. Тодорхой эрсдэлийн хувьд зардал-ашигын шинжилгээ хийж түүнийг бууруулах арга хэмжээ авахгүйгээр үлдээж, түүний оронд бусад аюулын эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах нь ихэвчлэн үр ашигтай байж болно.

**ЭРСДЭЛД СУУРИЛСАН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**  
 олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс ...

**Н.Энхбаяр**  
 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнгийн Эдийн засгийн аюулгүй байдлын судалгааны төвийн судлаач, эдийн засагч

"Урьдчилан сээрэмжлүүлэх, урьдчилан арга хэмжээ авах тогтолцооны үргэлжлэл болох сээрэмжлүүлэх мэдээллийн дараа үргэлжлүүлэн авах арга хэмжээг маш тодорхой болгох, үүнд үүрэг хүлээх байгууллагууд, субъектүүдийг тодорхой болгож тус тусын чиг үүргийг журамлах, үүнийг чанд мөрдүүлэх шаардлагатай."

**ЭРСДЭЛД СУУРИЛСАН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**  
 олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс ...

**Keiko Kitagawa**  
 Япон Улсын Сага Үндэсний Их сургуулийн Эмерит профессор, доктор (Ph.D)

"It is noticeable that effective risk reduction requires awareness and knowledge, scientific evidence, formation of an intent to act, identification and selection of a plan of action, and execution of the plan."

**ЭРСДЭЛД СУУРИЛСАН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**  
 олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс ...

**П.Лхамсүрэн**  
 МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

"Нийт экспортын дийлэнх хувийг эзэлдэг уул уурхайн гаралтай түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ тогтворгүй учир дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэр дундаа дотоодын гурилын үйлдвэрлэл нь ургацын буюу түүхий эдийн нийлүүлэлтийн тогтвортой байдлаас шууд хамаарна гэж үзвэл дотоодын хэрэглээг тогтвортой хангах зорилтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна."

**ЭРСДЭЛД СУУРИЛСАН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**  
 олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс ...

**П.Амарзаяа**  
 МУЗН-ийн Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн удирдлагын газрын ажилтан

"Олон нийтийн оролцоотойгоор эрсдэлийг бууруулах, аюулыг даван туулах, хүчин чадлаа нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэн нөөцөө ашиглан эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулж, хувь хүн, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх нь чухал байна."

**ЭРСДЭЛД СУУРИЛСАН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**  
 олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээс ...

**С.Энх-Амгалан**  
 Шинжлэх ухааны академийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн зөвлөх, доктор (Ph.D)

**Б.Саранцэцэг**  
 Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гамшиг судлалын төвийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд хурандаа

"Хот, хөдөөгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хүрээлэн байгаа орчны тэгш бус байдлыг тодорхойлох шалгуур элементүүд болох (i) байгаль-уур амьсгалын нөхцөл (ii), эрчим хүчний хангамж (iii), уул уурхайн баялаг, түүний тархалт (iv), хүн амын нутагшилт суурьшилт, шилжих хөдөлгөөн зэргийг судалснаар амьдрах таатай нутгийн бүсцэлийг тогтоох, тааламж муутай бүс нутагт татварын болон халамжийн бодлого хэрэгжүүлэх, шилжилт хөдөлгөөнийг бууруулах, тараан байршуулах, улмаар Монгол орны хүн амын нутагшилт, суурьшлын тэгш бус байдлыг тэнцвэржүүлэн хөгжүүлэх судалгаанд суурилсан загвар боловсруулах боломж бүрдэнэ."



ХОББИ

В.БАТСАЙХАН:

ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГАД АШИГЛАЖ БАЙСАН БҮХ ТӨРЛИЙН АВТОМАШИНЫ ЗАГВАР НАДАД БИЙ



Нэгэн аав, охины хамт нуурын эрэг дээр очжээ. Аав нь охиндоо хандан "яваад нуурын ус дулаан байна уу, хүйтэн байна уу үзээд ир" гэж гэнэ. Охин усанд хөлөө бага зэрэг дүрж үзээд, аав дээрээ гүйн ирж "Хүйтэн байна" гэхэд, аав нь охиноо тэвэрч аваад нуур руу шидчихэж. Охин гайхсан хэдий ч усанд дасах үед нуур тийм ч хүйтэн санагдсангүй. Тэр үед аав нь охиноосоо "Нуур ямар байна" хэмээн дахин асуужээ. Охин хариуд нь "Гоё байна" гэв. Харин аав, охиндоо хандан "ямар нэг юмыг мэдрэхийг хүсвэл бүхэл бие, сэтгэлээрээ тэр зүүлдээ орж бай" гэж захижээ.

Дээрх бяцхан түүхд өгүүлсэн шиг бүхий л зүрх сэтгэлээ хоббидоо зориулсан нэгэн эрхмийг энд онцолж байна. Энэ бол ОБЕГ-ын Эрсдэлийн удирдлагын газрын тасгийн дарга, дэд хурандаа В.Батсайхан. Тэрээр хуучнаар ЗХУ-д үйлдвэрлэж Монгол Улсын бүтээн байгуулалтад ашиглаж ирсэн 100 гаруй автомашины 1:43 масштаб хэмжээтэй моделийн цуглуулгатай. Түүний яриаг хүргэе.



-Яагаад машины модель цуглуулах болсон бэ. Хамгийн анхных ямар загвар байв?

-Миний аав жолооч, мэдээ орсон цагаасаа ЗИЛ-130 машины кабинд явдаг байлаа. Анх, олон жилийн өмнө дөө аавынхаа барьж байсан машинуудаар цуглуулгаа эхэлсэн. Харин гал унтраах машины цуглуулгыг 2010 оноос эхэлсэн.

Манай гал түймэртэй тэмцэх байгууллагад ашиглаж байсан бүх төрлийн автомашины загвар надад бий. Цуглуулгаа тоолдоггүй, бараг 200 дөхсөн байх. Монголд, зөвхөн надад байдаг цор ганц загвар ч бий.

-Цэргийн түүхийн музейд цуглуулгаараа үзэсгэлэн гаргасан гэсэн. Хүмүүс хэрхэн хүлээж авсан бэ?

-2022 оны гуравдугаар сард үзэсгэлэн гаргасан. Тэр үед би өөрөө эзгүй, Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомт дахь Шуурхай штабт томилолтоор ажиллаж таарсан юм. Тиймээс нэг найздаа тоолж хүлээлгэж өгөөд явсан. Хүмүүс их сонирхсон

гэсэн.

-Ийм төрлийн цуглуулгатай өөр хүн мэддэг үү?

-Олон байдаг байх аа. Сүүлийн үед хүмүүс аавынхаа барьж байсан машины моделийг их хийлгэдэг болжээ. Гэхдээ хүүхдийн тоглоомтой холихгүйгээр цуглуулдаг гэхээр тоо нь цөөрч магадгүй. Моделийг яг өмнө нь ашиглаж байснаар нь тоноглох чиглэлийн хөгжүүлэлтийг өөрийн урлантай Ү.Одонбаяр ах түлхүү хийж байгаа.

-Цуглуулгаа хадгалж, хамгаалахад бэрхшээл тохиолдох уу. Тухайлбал, зочилж ирсэн бага насны хүүхэд нэхэх зэргээр.

-Нарны хурц гэрэл тусахаас хамгаалах, тоос шороог нь арчих гээд ажил мундахгүй. Ер нь манайхан хүүхдүүдэд багаас нь хүний юманд зөвшөөрөлгүй ойртохгүй, ядаж музей үзэхдээ үзэмрт нь гар хүрэхгүй байх наад захын соёл, хүмүүжилд сургах хэрэгтэй. Миний цуглуулгын ирж үзсэн хүүхдүүд гэртээ хариад

тоглоомуудаа угааж цэвэрлэн, өрж тавьдаг болдог л гэсэн.

-Хамгийн дурсамжтай олдсон нь аль вэ. Зэвэрсэн хаягдсан модель олж засаж шинэчилж авсан гэх мэт?

-Байлгүй яах вэ. Хямдхан худалдаж аваад урландаа будаж тоноглоод нөгөө хүндээ буцаад харуулахаар танихгүй байх жишээтэй.

-Танд өөр төрлийн цуглуулга байдаг уу?

-Ном. Онцгой байдлын салбарт ажилладаг эрдэмтний хувьд дотоодод 20, гадаадад 23 илтгэл, өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна. Мөн 2021 оноос "Уур амьсгалын өөрчлөлт тарваган тахлын байгалийн голомтын биологийн төрөл зүйл, хөдлөл зүй, хүн амын зарим эрсдэлт хүчин зүйлд үзүүлэх нөлөө" суурь судалгааны ажлын удирдагчаар ажиллаж байна.

-Таны хоббиг хамгийн их дэмждэг хэн байдаг вэ?

-Мэдээж гэр бүлийнхэн. Гадаад явахдаа модель авчирч өгдөг найз нөхөд гээд дэмждэг хүмүүс олон.

ТАНЫ МЭДЛЭГТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны "Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай" 48 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 96 дугаар тогтоолоор баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III", "Монгол хэлний тухай хууль"-ийг хэрэгжүүлэх хүрээнд Онцгой байдлын байгууллагын газар, хэлтэс, анги байгууллагууд алба хаагчдад үндэсний бичгийн анхан шатны мэдлэг олгох шат дараалсан сургалтуудыг зохион байгуулж байгаа билээ. Тиймээс "Онцгой мэдээ" сонин та бүхний мэдлэгийг бататгах үүднээс Ардын баатар Ш.Чоймаагийн монгол бичгийг анхлан суралцагчдад зориулан гаргасан есөн цуврал хичээлийг хүргэж байна. Энэхүү хичээлээс анхан шатны мэдлэгтэй болсон нь мэдлэгээ бататгаж, шинээр суралцагсад нь системтэй мэдлэгийг авна гэдэгт итгэлтэй байна. Амжилт хүсье.



МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ

Цуврал 28

Handwritten Mongolian text in a grid format, likely a lesson or a collection of sayings.

ОНЦГОЙ МЭДЭЭ

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ:

"Эрсдэлгүй амьдралын төлөө" ТББ

Эхийг Онцгой байдлын ерөнхий газрын Олон нийттэй харилцах хэлтэст бэлтгэж "Чөлөөт хэвлэл сан"-гийн хэвлэл үйлдвэрт хэвлүүлэв.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар-14250 Сүхбаатар дүүрэг, Партизаны гудамж-6

Утас: 976-11-262073

Факс: 976-11-324977

Веб хуудас: www.nema.gov.mn www.ontsgoisur.gov.mn

И-Мэйл: obeg.onht@gmail.com